

**ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД СОНГУУЛЬД БИЕ ДААСАН
ХЯНАЛТ, АЖИГЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ТҮГЭЭМЭЛ ЗАРЧМЫН
ТУНХАГЛАЛ**

ХИЙГЭЭД

**ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛСӨН НАМ БУС СОНГУУЛИЙН АЖИГЛАГЧ,
ХЯНАГЧИЙН БАРИМТЛАХ ЁСЗҮЙН ДҮРЭМ**

*Сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын олон улсын сүлжээ
(СХИНБОУС)-
-нээс бэлтгэв*

Агуулга:

- 1) Иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд бие даасан ажиглалт, хяналт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглал
- 2) Иргэдийг төлөөлсөн нам бус сонгуулийн ажиглагч, хянагчийн баримтлах ёсзүйн дүрэм
- 3) Талархлын үг
- 4) Хавсралт - Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглах, хянахтай холбоотой олон улсын тунхаглал, баримт бичгийн жагсаалт

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗҮГЭЭС СОНГУУЛЬД БИЕ ДААСАН ХЯНАЛТ, АЖИГЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ТҮГЭЭМЭЛ ЗАРЧМЫН ТУНХАГЛАЛ

Оршил

Жинхэнэ ардчилсан сонгууль гэдэг нь ард түмэн тусгаар тогтнол, халдашгүй эрх дархаа хамтарсан байдлаар илэрхийлж байгаа хэрэг мөн бөгөөд иргэний заяагдмал эрхийн нэг билээ. Энэ талаар дэлхийн олон улс орны үндсэн хуульд төдийгүй Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ), бус нутгийн засгийн газар хоорондын болон бусад холбогдох байгууллагуудын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгажээ.

Тухайлбал, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 21-р зүйлд “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” гэжээ. Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын факт (одоогоор дэлхийн 165 улс орон элсэн орсон)-ын 25 дугаар зүйлд “Иргэн бүр 2 дугаар зүйлд дурдсан аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр [арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр] дараахь эрх, боломжийг эдэлнэ. Үүнд: сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” гэж заасан байдаг. Дээрх хоёр зүйлд дурдсан боломжууд, сонгуультай холбоотой эрхүүд нь “иргэн бүр өөрсдийн шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж засгийн газрын болон төрийн хэрэгт оролцох эрхтэй” гэсэн үндсэн эрхийг гүнзгийрүүлэн баталгаажуулахад чиглэжээ.

Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс улстөрийн намаас тусдаа, хараат бусаар иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн сонгуулийг ажиглаж, хянах болсон нь дэлхий дахинаа ардчиллын хөгжлийн хамгийн бодит бөгөөд чухал хэмжүүрийн нэгээр тооцогдож байна. Өнгөрсөн хорь гаруй жилийн турш дэлхийн таван тивийн 90 гаруй улс оронд сая сая ард иргэд улс төрийн өрсөлдөгч хүчнүүд болон төрийн хариуцлагатай байдлыг сайжруулах, сонгуулийн шударга явагдах нөхцлийг ханган бэхжүүлэх зорилгоор сонгуулийг ажиглах, хянах үйл ажиллагаанд нэгдэн оролцжээ. Энэ нь төрийн хариуцлагатай байдал болон ардчиллын хөгжилд түлхэц болж, болзошгүй зөрчилдөөнийг намжаах, хуурамч бус жинхэнэ сонгууль явуулахад үнэлж баршгүй тус дэм болж байна.

Улстөрийн намаас тусдаа иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулсан байгууллагууд сонгуулийн үйл явцад хараат бус, бие даасан хяналт, ажиглалт хийж байгаа нь иргэд төрийн үйл хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлж буй нэг хэлбэр бөгөөд энэ эрх нь “хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны эрх мэдэл”-тэй холбоотой, “бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон төрийн захиргааны бүх тал”-ыг хамарсан асуудал юм (НҮБ-ын Хүний эрхийн хороо, 25-р Ерөнхий тайлбар, 5-р зүйл). Ийнхүү улстөрийн намаас тусдаа байгууллагууд сонгуулийг ажиглаж, хяналт тавих нь төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны гол суурь болох иргэдийн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх нэг хэлбэр болохын зэрэгцээ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт хийгээд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, илт тод байдлын амин сүнс болсон мэдээлэл шаардах, авах, дамжуулах эрхийг хэрэгжүүлж буй хэрэг юм. Иргэд хуурамч бус жинхэнэ сонгуульд оролцох эрхтэй төдийгүй сонгуулийн процесс өөрсдийнх нь хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлэх нөхцлийг хангаж чадаж буй эсэх, сонгуулийн дүн түүнийг үнэн зөвөөр тусган илэрхийлж байгаа эсэхийг мэдэх эрхтэй тул сонгуулийн процесс иргэдийн хараа хяналт дор, ил тод, нээлттэй байх нь зүйд нийцнэ.

Нам бус сонгуулийн ажиглагчдыг сонгуулийн суурь үндэс болох иргэний болон улс төрийн эрхүүдээр мэргэшсэн хүний эрхийн мэргэжилтнүүд гэж үзэх ёстой. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих, түүний дотор сонгогч болон сонгогдогчийг хуулиар эрх тэгш хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх гэх мэт эрхээ эдлэх боломж олгох, түүнчлэн сонгуультай холбоотой эрх нь зөрчигдсөн бол засч залруулах үр дүнтэй арга хэмжээ авах нь жинхэнэ сонгуулийн гол шалгуур шаардлага юм.

Дээрх сонгуультай холбогдох эрхүүд, тэдгээрт хамаатай эрх зүйт ёсны асуудлуудад тухайн улс орны өөрийнх нь улстөрийн уламжлал, түүхээс нь улбаатай янз бүрийн хүчин зүйлүүд, урт хугацаанд бүрэлдэж тогтсон институц, процесс нөлөөлж байдаг. Сонгууль нь иргэдэд эдийн засаг, соёл, нийгмийн сайн сайхны төлөө хүсэл тэмүүлэл, санал бодлоо нэгтгэн илэрхийлэх, түүнчлэн энх тайван, аюулгүй байдал болон бусад асуудлаа өөрсдийн төлөөлөгчөөр уламжлан шийдвэрлэх боломж олгоно. Иймд жинхэнэ сонгууль нь ардчилсан засаглалыг бүрдүүлэх нөхцөл төдийгүй ардчиллын өргөн цар хүрээний хөгжлийн салшгүй хэлбэр юм.

Эрхийг дагаж үүрэг хариуцлага бий болдог тул улстөрийн намыг бус иргэдийг төлөөлсөн сонгуулийн ажиглагч, хянагчид үйл ажиллагаагаа хариуцлагатай явуулах ёсзүйн үүрэг хүлээнэ. Сонгуульд ажиглалт хяналт хийдэг үндэсний иргэний нийгмийн байгууллагууд, тэдгээрийг нэгтгэсэн олон улсын сүлжээдээс гаргасан янз бүрийн баримт бичиг, тунхагыг ерөнхийд нь харахад “нам бус байхын тулд алагчлалаас ангид хандлага, нарийн чанд ажиллах мэргэжлийн ур чадвар амин чухал” болохыг онцлон тэмдэглэжээ.

Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа тухайн улс орны нөхцөл байдалд тохирох сайн туршлагад тулгуурласан найдвартай аргачлал ашиглан дээд зэргээр төвийг сахин үнэнч шударга ажиллах өндөр стандартыг мөрдөх шаардлагатай. Сонгуулийг ажиглах, хянах гол зорилго нь болзошгүй булхай, гажуудлаас сэргийлэх буюу тэдгээрийг илчлэх замаар сонгууль шударга явагдахад хувь нэмэр болох, сонгуулийн болон болон улстөрийн үйл явцыг сайжруулах зөвлөмж өгч сонгуультай холбоотой болзошгүй хүчирхийллээс сэргийлэхэд чиглэх ёстой. Мөн сонгуульд иргэд оролцоход аливаа ялгаварал, үндэслэлгүй хязгаар саад болохоос сэргийлж тэдний төрийн үйл хэрэгт оролцох эрх эдлэхэд дэмжлэг үзүүлэн сонгуулийн үйл явцад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх зорилго агуулна.

Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа олон улсын болон бүс нутгийн тунхаг бичиг, конвенц, тунхаглал, бусад баримт бичигт зааж тусгасан стандарт, зарчим, мөн олон улсын хүний эрхийн баримт бичигт багтсан ардчилсан сонгуулийн талаарх үүрэг хариуцлага, дотоодын холбогдох хууль, дүрэм журамд тулгуурлаж сонгуулийн асуудал эрхэлсэн хороо, төрийн бусад холбогдох байгууллагуудтай аль болох хамтран ажиллахыг зорих ёстой.

Сонгуулийн чанараар засаглалын ардчилсан шинж чанарыг үнэлэх ба энэ нь мөн сонгуулийн үр дүнд үүссэн төр засгийн мөн чанарыг илэрхийлэх чухал үзүүлэлт болно. Нам бус сонгуулийн ажиглалт, хяналтын хүрээнд бий болгосон иргэдийн ур чадвар, тэдний санаачилгаар байгуулсан холбоо сүлжээ нь сонгуулийн шударга байдлыг сахин хамгаалаад зогсохгүй ил тод, хариуцлагатай, иргэдийг төлөөлсөн ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дөхөм болж байна.

Иймд:

Иргэний нийгмийн сонгуульд тавих хяналт, ажиглалт нь дэлхий дахинд улам бүр түгээмэл чиг хандлага болж байгаа бөгөөд таван тивийн 90 гаруй улс оронд олон сая иргэд төрийн үйл хэрэгт оролцох эрхээ эдэлж байгаа нэг хэлбэр болохыг **онцолж**,

Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн сонгуулийн үйл явцыг ажиглаж, хянах нь ардчилсан засаглал, эрх зүйт ёс, шударга

сонгуулийн үндсэн суурь болох иргэний болон улс төрийн эрхүүдэд чиглэсэн хүний эрхийг хамгаалах онцгой хэлбэр болохыг **ухамсарлан**,

Иргэний нийгмийн зүгээс сонгуульд хараат бус хяналт тавих нь сонгуулиас үүдэлтэй болзошгүй хүчирхийллээс сэргийлэх, намжаах, ардчиллыг өргөн утгаар нь хөгжүүлэх, сонгуулийг зохион байгуулах үйл явц, сонгуулийн эрхзүйн орчны ардчилсан чанарыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулдаг болохыг **тэмдэглэн**,

Сонгуулийн асуудал эрхэлсэн болон бусад холбогдох төрийн байгууллагууд ардчилсан сонгуулийг жинхэнэ утгаар нь зохион байгуулах чухал үүрэг хүлээх ба улстөрийн намууд болон нэр дэвшигчид нь сонгогдох эрхээ эдлэх, иргэд сонгох эрхээ эдлэхийн сацуу сонгуулийн болон холбогдох улстөрийн үйл явцад бүрэн оролцох, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс сонгуульд бие даасан хяналт тавих тус тусын онцгой үүрэг гүйцэтгэдэг болохыг **онцолж**,

Сонгуульд хараат бус ажиглалт, хяналт хийснээр иргэний нийгмийн байгууллага нь сонгогчдын өмнө төдийгүй сонгуульд өрсөлдөж буй талууд, сонгуулийн маргааныг шийдвэрлэх болон сонгуулийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий талуудын өмнө хариуцлага хүлээх учиртайг **баталгаажуулж**,

Шударга ардчилсан сонгууль нь Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын фактын 25-р зүйл, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21-р зүйлд заасанчлан иргэд өөрсдийн хүсэл зоригоо илэрхийлэх үндэс суурийг бүрдүүлэх, улстөрийн хүчний төлөөх өрсөлдөөнийг энхийн аргаар шийдвэрлэх арга хэрэгсэл болохыг **чухалчилж**,

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25-р Ерөнхий тайлбарын 5, 8, 20-р зүйлүүдэд Иргэний болон улстөрийн эрхийн тухай олон улсын фактанд оролцогч 165 орон иргэдийг олон нийтийн хэлэлцүүлэг, яриагаар дамжуулж төрийн үйл хэрэгт өргөн цар хүрээгээр оролцуулах, холбогдох арга хэмжээг зохион байгуулах талаар заасан бөгөөд Хүний эрхийн хорооноос “санал өгөх, тоолох үйл явцад бие даасан ажиглалт байх ёстой ба үүний үр дүнд сонгогчид сонгуулийн шударга байдалд итгэлтэй болно...” гэснийг **баталж**,

Сонгуулийн үйл явц, сонгуультай холбоотой бусад үйл ажиллагааг хөндлөнгөөс хянах ажиллагаанд шүүх, улс төрийн хүчин, нэр дэвшигчид болон тэдний төлөөлөгчдөөс гадна нам бус иргэний нийгмийн байгууллагууд басхүү чухал оролцогч болохыг **бататган**,

Бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллагуудын тунхаг бичиг, конвенц, тунхаглал болон төрийн бус байгууллагуудын гаргасан зарчим, бусад баримт бичгүүдэд шударга ардчилсан сонгуулийн эрхийг зааж, иргэний нийгмийн байгууллагуудын сонгуулийг ажиглаж, хянах оролцоог дэмжсэн байдгийг, тухайлбал, Европийн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 1990 оны Копенгагений баримт бичгийн 8-р зүйл, 2007 оны Ардчилал, сонгууль болон засаглалын талаарх Африкийн тунхаг бичгийн 22-р зүйлд энэ талаар зааж тусгасныг **тэмдэглэж**,

Иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд ажиглалт, хяналт хийхэд мөрдөх зарчим нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей (A/Res/64/155, 2010 оны 3 дугаар сарын 8-ны өдөр)-гаас сайшаасан 2005 оны *Олон улсын сонгуулийг ажиглах зарчмын тунхаглал* (одоогийн байдлаар 35 засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагууд нэгдсэн)-д дурдсан зүйл заалтуудтай нийтлэг агуулгатай бөгөөд иймд энэхүү тунхаглалын 1-3 дугаар зүйлүүд нь дээрх тунхаглалын 1-3 дугаар зүйлүүдтэй утга давхцаж байгааг, түүнлэн хоёр тунхаг нь олон зүйлээр адил төстэйг **онцлон**,

Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс сонгуульд бие даасан хяналт, ажиглалт хийх тухай түгээмэл зарчмын тунхаглал болон холбогдох ёсзүйн дүрмийг зөвшөөрч, үүгээр дараах зүйл, зарчмыг тунхаглаж байна.

Үүнд:

Шударга ардчилсан сонгууль

1. Шударга ардчилсан сонгууль нь ард түмэн тусгаар тогтнолоо нэгдмэл байдлаар илэрхийлж буй хэрэг бөгөөд төрийн бүх эрх мэдэл иргэдийн чөлөөтэй илэрхийлсэн хүсэл зоригоос үүдэлтэй болно. Жинхэнэ ардчилсан, тогтмол сонгуульд сонгох, сонгогдох эрх нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх юм. Шударга ардчилсан сонгууль нь энх тайван, тогтвортой байдлыг хамгаалах гол зэмсэг болох агаад ардчилсан засаглалын эхлэл суурь болно.
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон олон улсын бусад баримт бичигт зааснаар хүн бүр хүний эрхийн зарчмуудаар хориглосон аливаа ялгаварлан гадуурхал болон бусад зүй бус хязгаар саадгүйгээр өөрийн улс орны төрийн үйл хэрэгт оролцох эрхтэй, ийм боломжоор хангагдах ёстой. Энэ эрхээ шууд буюу бүх нийтийн сонгууль, санал асуулгад оролцох, сонгуульд өрсөлдөх гэх мэтээр хэрэгжүүлэх буюу эсвэл чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж эдэлнэ.
3. Ард түмний хүсэл зориг нь төрийн бүх эрх мэдлийн үндэс бөгөөд энэхүү хүсэл зориг нь шударга, тогтмол явагддаг сонгуулиар тодорхойлогдох ёстой. Ийм сонгууль нь бүх нийтийн, тэгш байх зарчмаар явагдаж иргэд чөлөөтэй оролцон сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжтой байх ёстой. Иймд хэд хэдэн чухал эрх, эрх чөлөө, үйл явц, хууль, институциуд нийлснээр шударга ардчилсан сонгуулийг явуулах нөхцөл бүрдэнэ.

Сонгуулийн үйл ажиллагаанд улстөрийн намаас тусдаа бие даасан хяналт тавих нь

4. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс сонгуульд бие даасан хяналт, ажиглалт хийнэ гэдэг нь улстөрийн хувьд төвийг сахисан, шударга, аливаа ялгаварлан гадуурхлаас ангид зарчмаар иргэдийг идэвхжүүлэн сонгуулийн үйл явц, өрнөлийг ажиглах, үр дүнгийн талаар мэдээлэх үйл ажиллагаанд татан оролцуулахыг хэлэх ба энэ нь иргэд төрийн үйл хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлэх буй нэг хэлбэр гэж үзнэ. Үүнд, сонгуультай холбоотой улс төрийн орчин, эрхзүйн тогтолцоо, институц, үйл ажиллагааг хараат бус, системтэй, олон талаас нь үнэлж; нэг талыг барилгүй, үнэн зөв, цагт тухайд нь дүн шинжилгээ хийх; алагчлалгүй бөгөөд үнэн зөв, нягт нарийн байх ёсзүйн өндөр стандартын дагуу дүгнэлтээ гаргаж; улмаар шударга ардчилсан сонгууль явагдах нөхцлийг хангахад чиглэсэн зөвлөмж гаргах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, эрхзүйн орчинд туссан өөрчлөлтийг сонгуулийг зохион байгуулах арга барилд нөлөөлж өөрчлөх, сонгууль болон улстөрийн үйл явцад иргэд бүрэн оролцоход тулгарч буй аливаа саадыг арилгах замаар хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа багтана.
5. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа сонгуульд өрсөлдөж буй нам, нэр дэвшигчид, бүх нийтийн санал хураалт явуулж буй аливаа асуудлаар дэмжсэн буюу эсэргүүцсэн байр суурьтай талуудад тэгш хандаж, төвийг сахина. Улстөрийн хувьд төвийг сахих ба сонгуулийн үр дүнгийн хувьд зөвхөн хэр шударга процессын үр дүн болох, түүнчлэн энэ талаарх мэдээлэл олон нийтэд шуурхай, үнэн зөв, ил тод хүрч байгаа эсэхэд голлон анхаарна.
6. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа сонгуулийн асуудал эрхэлсэн болон төрийн бусад холбогдох байгууллагуудтай аль болох хамтран ажиллахыг зорих ба сонгуулийн үйл явц, түүнийг гардан зохион байгуулж буй сонгуулийн хороодын ажилтнууд, сонгуульд оролцогч нам эвсэл, нэр дэвшигчид болон сонгогчдод хөндлөнгөөс саад учруулахгүй. Сонгуульд бие

даасан хяналт, ажиглалт хийж буй байгууллагууд нь сонгуулийн үйл явцыг сайжруулж боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж өгөх, мэдээлэл шаардах, авах, эсвэл мэдээлэл өгөх зорилгоор сонгуулийн асуудал эрхэлсэн хийгээд төрийн бусад эрх бүхий байгууллагууд, сонгуульд оролцогч талуудтай харилцаж, уулзах боломжоор хангагдах ёстой.

7. Иргэний нийгмийн байгууллагууд нь сонгуулийг ажиглаж, хянахдаа төрөөс, түүний дотор сонгуулийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас хараат бус байх зарчмыг баримтлах ба иргэдийн шударга ардчилсан сонгуулиар чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж болон төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, тэдний нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго агуулсан байна.
8. Сонгуульд ажиглалт, хяналт хийх иргэний нийгмийн байгууллагуудын санхүүжилтийн талаар мэдээлэл ил тод байх ёстой. Хяналтын үйл ажиллагаагаа алагчлалгүй, үнэн зөв, цаг хугацаанд нь явуулахад саад болох ашиг сонирхлын зөрчил үүсгэх аливаа эх үүсвэрээс санхүүжилт авахыг хориглоно. Сонгуулийн ажиглагчаар ажиллах, мониторинг хийх иргэн нь улстөр, эдийн засаг хийгээд бусад ашиг сонирхлын зөрчилтэй байхыг цээрлэнэ.
9. Сонгуульд хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллага нь сонгуулийн үйл явцыг аль болох бүхэлд нь хянахыг зорих ба сонгууль явагдах орчин нөхцөлд нөлөөлж болох хүчин зүйлсийн талаар ч мөн цогц мэдээлэл системтэй цуглуулж, шударгаар шинжлэн дүгнэнэ. Ийнхүү ажиллахдаа нэг байгууллага дангаар юмуу иргэний нийгмийн байгууллагууд хамтран эвсэл болж, эсвэл бие даасан хэд хэдэн байгууллага нэгдэн сонгуулийн үйл явцын тодорхой асуудлыг тус тусдаа хариуцан авч хамтран ажиллаж болно. Сонгуулийн хяналт, ажиглалтын үр дүнгийн талаар ойлгомжгүй байдал үүсэх, нэг асуудлаар олон байгууллага ажиллаж давхардал гарахаас зайлсхийж иргэний нийгмийн байгууллагууд өөрийн улсын нөхцлийг харгалзан хамтын ажиллагааг дээд зэргээр ашиглахыг чармайх ёстой.
10. Иргэний нийгмийн байгууллагууд сонгууль, эсвэл сонгуулийн үйл явцаас тодорхой асуудлыг сонгон ажиглаж, хянахаар шийдэх нь сонгуульд итгэл үнэмшил дутсанаас шалтгаалаагүй. Ийм хяналтын зорилго нь дотоодын хуульд заасан шаардлагууд болон тухайн орны олон улсын гэрээ, бусад баримт бичгээр хүлээсэн үүрэгт сонгуулийн үйл явц хэрхэн нийцэж байгаад дүгнэлт өгөх, үүний тулд сонгуулийн үйл явцыг бүхэлд нь буюу тодорхой асуудлыг сонгон нарийн, шударга, аль болох системтэй үнэлэхэд оршино. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс өөрсдийнх нь үйл ажиллагаа ардчилсан зарчмаас илэрхий гажсан сонгуулийг зөвтгөж буй мэт ойлголт төрүүлэхээс зайлсхийж олон нийтэд хандсан мэдэгдэл гаргах, шаардлагатай бол ажиглалт, хяналтын үйл ажиллагаагаа зогсоох, энэ үйлдлийнхээ үндэслэлийг нийтэд тодорхой мэдэгдэх зэрэг арга хэмжээг цаг алдалгүй авна.
11. Энэ тунхаглалыг дэмжигч байгууллагууд нь олон улсын түвшинд шударга ардчилсан сонгуулийн стандарт, зарчим, үүрэг хариуцлагыг тогтооход бүс нутгийн байгууллага, олон улсын төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачдын хичээл зүтгэлээр ихээхэн ахиц дэвшил гарсан болохыг ухамсарлан сонгуулийн асуудлаар дүн шинжилгээ, дүгнэлт хийх, тайлбар, зөвлөмж гаргахдаа энэ талаар мэдээлэл цуглуулж, суралцаж, ашиглах, ажиглалт болон хяналтын үйл ажиллагаандаа ямар шалгуур үзүүлэлт ашиглаж буйгаа илт тод мэдээлэх үүрэг хүлээнэ.
12. Сонгуулийг ажиглаж, хянаж буй иргэний нийгмийн байгууллагууд аль нэг талыг бариагүй, үнэн зөв мэдээллийг цаг алдалгүйгээр олон нийтэд тайлан, мэдэгдэл болон бусад хэлбэрээр хүргэх үүрэгтэй ба үүнд сонгуулийн ажиглалтын, түүнд хийсэн шинжилгээ, дүгнэлт, сонгуулийн үйл явцыг сайжруулахад чиглэсэн

зөвлөмж танилцуулсан байна. Ажиглалт, хяналт нь сонгуулийн үйл явцыг бүхэлд нь бус тодорхой нэг буюу цөөн тооны асуудлаар хязгаарлагдаж байгаа тохиолдолд энэ талаар тайлан, олон нийтэд хандсан мэдэгдэл бусад мэдээлэлдээ заавал дурдана. Сонгуульд ажиглагчаар оролцсон байгууллагууд дүнг шударгаар шинжлэхийн зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллага болон бусад байгууллагын (эдгээр нь дүгнэлтийн гол үндэслэл болсон тохиолдолд эх сурвалжийг дурдах ёстой) гүйцэтгэсэн сонгуулийн үйл ажиллагааны талаарх үнэлгээг анхаарч үзнэ.

13. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн орчин, сонгуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч ажиглах, хянах үйл ажиллагаандаа олон янзын аргачлал, техник хэрэглэх бөгөөд үнэн зөв, шударга, шуурхай дүгнэлт гаргахын тулд тухайн улс орны нөхцөлд тохирох, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд нийцэх хамгийн шилдэг, системтэй аргачлал техникийг ашиглахыг хичээх ёстой.
14. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа сонгуулийн өмнөх, дараах өдөр болон сонгуулийн өдрийн үйл явцыг үнэлэх статистикт суурилсан аргачлал хэрэглэж болох ба үүнд тухайлбал, сонгуулийн үр дүнг үнэн зөв гарсан эсэхийг шалгахдаа зэрэгцээ буюу параллель санал тооллого аргачлал ашиглаж болно. Гэхдээ ийм аргачлалд тулгуурласан ажиглалтын үр дүнг мэдээлэхдээ баримт мэдээллийн бүрэн бүтэн үнэн зөв байдал, статистикийн мэдээг шинжлэх нарийвчлал болон сонгуулийн холбогдох дүрэм журмыг харгалзан олон нийтэд хүргэх хугацааг тогтооно. Түүнчлэн статистик түүврийн талаар болон алдааны хязгаарын тухай заавал мэдээлэх үүрэгтэй.
15. Иргэний нийгмийн байгууллагуудын сонгуульд тавих хяналт нь сонгуулиас үүдэлтэй гарч болзошгүй хүчирхийллээс сэргийлэх, намжаах, сонгуулийн эрх зүйн орчныг сайжруулах, сонгуулийн болон улстөрийн үйл явцын чанарыг сайжруулах, ардчиллыг өргөн утгаар нь хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болдог. Иймд сонгуулийг ажиглаж, хянах үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд нь өөрсдөд нь олгогдсон боломжийн хүрээнд улстөрийн болон сонгуулийн үйл явцыг хүчирхийллээс ангид тайван үргэлжлүүлэх, сонгуулийн эрх зүйн орчин болон сонгуулийн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сонгуульд оролцоход эмэгтэйчүүд, залуус, цөөнх болон хүн амын бусад бүлэгт тулгарч буй саадыг зайлуулах, түүнчлэн төрийн үйл хэрэгт иргэдийг оролцуулах нөлөөллийн арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

Ажиглаглалт, хяналт хийх асуудал, шаардлагатай нөхцөл

16. Иргэний нийгмийн байгууллагуудын сонгуульд тавих хяналт, ажиглалт, дүн шинжилгээ нь сонгуулийн үйл явцыг бүхэлд нь цикл байдлаар хамрахыг зорих ёстой ба сонгуулийн чанар, онцлогт нөлөөлөх улстөрийн нөхцөл байдалд ч анхаарал хандуулах ёстой. Сонгуулийн үйл явцыг бүхэлд нь хамарсан цогц ажиглалт, хяналт хийх боломжгүй нөхцөлд санал хураах өдрөөс өмнөх болон дараахь хугацаанд тохиох сонгуулийн үйл явц, холбогдох хүчин зүйлүүдийг харгалзан тооцож, сонгуулийн өдөр хийх ажиглалтаа улстөрийн орчин болон сонгуулийн ерөнхий үйл явцтай холбон авч үзэх нь зүйд нийцнэ. Сонгуулийн өдрийн үйл ажиллагааг хэт онцлон авч үзэх нь сонгуулийн үйл ажиллагааны мөн чанарын талаар олон нийтэд ташаа ойлголт төрүүлэх эрсдэлтэй.
17. Сонгуулийн ажиглалт, хяналтад дараахь үйл явцыг хамруулах ба зарим нөхцөлд эдгээрийг бүгдийг нь хамарсан ажиглалт, хяналт хийх боломжгүйг энд дурдах нь зүйтэй:
 - а) Үндсэн хууль, сонгуультай холбоотой бусад хууль тогтоомж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлага, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан дүрэм журмын агуулга, хэрэгжилт;

- b) Сонгуулийг удирдан зохион байгуулах болон төрийн зүгээс харицан гүйцэтгэж буй бусад холбогдох үйл ажиллагааны үр дүн, ил тод, шударга байдал;
- c) Сонгуулийн байгууллага, хороодын гишүүдийг томилох, дахин томилох үйл явц;
- d) Сонгуулийн тойргуудын хил хязгаарыг тогтоох үйл явц;
- e) Улстөрийн нам, нэр дэвшигчийг бүртгэх болон бүх нийтийн санал хураалт явуулах асуудлыг тогтоох шалгуур, процедур;
- f) Улстөрийн нам, эвсэл сонгуульд оролцуулах нэр дэвшигчдээ сонгох, кампанит ажил явуулах гэх мэт асуудалтай холбоотой хуулиар болон ёс зүйн дүрмээр хүлээсэн үүргээ хэрхэн гүйцэтгэх байдал;
- g) Улстөрийн нам болон нэр дэвшигчийн санхүүжилт, кампанит ажлын зардал, тэдгээрийг хянах процесс;
- h) Гадны байгууллагууд сонгуульд нэр дэвшигчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, олон улсын хэвлэл мэдээллийнхэн тэнцвэргүй мэдээлэл түгээх гэх мэт олон улсын байгууллага, гадна этгээдийн оролцоонд тавих хяналт;
- i) Сонгуультай холбогдуулан төрийн нөөцийг аливаа байдлаар ашиглах, улстөрийн тодорхой нам, нэр дэвшигчид, бүх нийтийн санал хураалт явуулж буй асуудлаар дэмжсэн болон эсэргүүцсэн байр суурьтай байгаа талууд давуу тал зүй бусаар олж авах;
- j) Сонгуультай холбоотой авилгыг илрүүлэхэд авилгын эсрэг хууль, авилгын талаар мэдээлсэн “шүгэл үлээгч”-ийг хамгаалахтай холбоотой хууль, дүрэм журмыг ашиглах;
- k) Кампанит ажлын материал тараах болон тайван жагсаал цуглаан хийх гудамж талбайн зөвшөөрөл олгох гэх мэт төрийн албан хаагчид болон хүчний байгууллагуудын үйл ажиллагаа;
- l) Улс төрийн нам, нэр дэвшигчид, бүх нийтийн санал асуулга явуулж буй асуудлаар эсрэг болон дэмжсэн байр суурьтай талуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэгш, тэнцвэртэй үйлчлэх байдал, түүнийг зохицуулсан хуулийн заалт, дүрэм журмын хэрэгжилт;
- m) Улсын мэдлийн, олон нийтийн, хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуульд өрсөлдөгчдийн талаар болон бүх нийтийн санал асуулга явуулж бус асуудлаар дэмжсэн болон эсрэг байр суурьтай талуудын тухай мэдээлэх байдал, холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилт, үүнд тухайлбал, цацагдаж буй мэдээллийн чанар, тоо хэмжээ, сонгууль, бүх нийтийн санал асуулгад сонгогч шийдвэрээ гаргахад тустай асуудлаар мэдээлэл өгөх байдал зэрэг багтана;
- n) Улстөрийн нам, нэр дэвшигчид, түүнчлэн бүх нийтийн санал асуулга явуулж буй асуудлаар дэмжсэн болон эсрэг байр суурьтай байгаа талууд сонгогчдын дэмжлэгийг олж авах зорилгоор хуулийн хүрээнд кампанит ажил аливаа саадгүйгээр чөлөөтэй зохион байгуулах боломж;
- o) Нийгмийн цөөнх сонгуульд оролцож шийдвэр гаргахад шаардагдах бүрэн бөгөөд үнэн зөв мэдээлэл хайх, олж авах боломж;
- p) Сонгогчдын нэрийн жагсаалтын бүрэн бүтэн байдал, сонгуулийн эрх бүхий иргэдийн бүртгэлийн мэдээллийн үнэн зөв байдал;
- q) Сонгогч, нэр дэвшигчид, тэдний дэмжигчид хүчирхийлэл, сүрдүүлэг, авилга болон ёс хонзонгоос айж эмээлгүй сонгуульд оролцох боломжтой эсэх, тухайлбал цагдаа, прокурор, шүүх бусад хүчний байгууллагуудын зүгээс хуулийн дагуу эрх тэгш, найдвартайгаар аюулгүй байдлыг хангах байдал;

- г) Сонгогчдын боловсролд чиглэсэн төрийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хангалттай байдал, үүнд хэзээ, хэрхэн, хаана, яаж бүртгүүлэх, санал өгөх талаар болон саналын нууцлалын баталгаа гэх мэт асуудлаар иргэдэд хангалттай мэдээлэл хүрч буй эсэх;
- с) Санал хураах байрны байршлын тохиромжтой байдал, тоног төхөөрөмжийн хангалт;
- т) Санал хураах байранд саналын хуудас, сонгуультай холбоотой бусад чухал материал хүргүүлэх, хүлээж авах, хадгалах үйл явц;
- у) Сонгогчдын бүртгэлийг цахимжуулах, электрон аргаар санал авах, үр дүнг гаргах, сонгуулийн бусад үйл ажиллагаа явуулахад электрон техник технологи ашиглахтай холбоотой бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх бүх үе шат;
- в) Сонгуулийн технологийн үр ашигтай, тохиромжтой, найдвартай байдал,
- w) Санал хураах үйл ажиллагаа (цөөнхийн хэл дээр сонгууль явуулах үйл явц бас хамрагдана), сонгуулийн дүнг тоолж гаргах, зарлах үйл явц, эдгээр үйл явцын ил тод байдал, алдаа болон гадны зүй бус нөлөөнөөс хамгаалагдсан байдал;
- х) Сонгуулийн маргаан шийдвэрлэх үйл явц, үүнд иргэд, сонгогчид, нэр дэвшигчид, бүх нийтийн санал асуулга явуулж буй асуудлаар дэмжсэн болон эсрэг байр суурьтай талуудын гаргасан гомдол, маргааныг хүлээн авч, шийдвэрлэх процесс, сонгуулийн эрхийн зөрчлийг үр дүнтэй арилгах арга хэмжээ;
- у) Сонгуулийн эрх, үүрэг хариуцлагыг заасан хуулийг зөрчсөн тохиолдолд зохих хуулийн дагуу арга хэмжээ авах, торгууль шийтгэл оногдуулах, захиргааны, иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэж, шийдвэрлэх үйл явц;
- z) Сонгуулийн өмнө болон дараа сонгуулийн хууль, холбогдох дүрэм журам, сонгууль зохион байгуулах арга, процесст оруулах өөрчлөлт, шинэчлэл.

18. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд үр дүнтэй ажиглалт, хяналт хийхэд наад захын зарим нөхцөл хангагдсан байх шаардлагатай. Үүнд:

- а) Ажиглагчдад өөрсдөд нь болон гэр бүлийн гишүүдэд нь эдийн засгийн хувьд болоод аюулгүй байдалд нь ямарваа эрсдэл учрахгүй байх нөхцөлд хяналт хийх боломжтой байх ёстой.
- б) Сонгуулийн асуудал эрхэлсэн болон бусад холбогдох төрийн байгууллагууд сонгуулийн өдөр болон түүнээс өмнө болон хойно сонгуульд хөндлөнгийн хяналт тавьж буй иргэний нийгмийн байгууллагууд, нам бус ажиглагчдад санал хураах байранд нэвтрэх боломж өгөх, бусад боломж, мэдээллээр ханган төрийн хэрэгт оролцох эрхээ саадгүй эдлэх боломж олгох ёстой. Ингэхдээ сонгуульд ажиглалт тавих магадлан итгэмжлэлийг удаашруулалгүй ялгаварлан гадуурхалгүй, үндэслэлгүй шалтгаан дурдан хориг тавихгүйгээр олгох, иргэний нийгмийн ажиглагчдад хэвлэл мэдээлэл болон улс төрийн нам, нэр дэвшигчийн ажиглагч, олон улсын сонгуулийн ажиглагчдаас бага эрх олгох зэргээр хавчихгүй байх ёстой.
- с) Сонгууль эрхэлсэн байгууллагууд, төрийн бусад эрх бүхий холбогдох байгууллагууд цаг тухайд нь мэдээлэл авах боломжийг олгож сонгуулийн ил тод байдлыг хангах ёстой. Үүнд, сонгуулийн хэсгийн хороод дээр нэгтгэсэн сонгуулийн дүн болон дээд шатны хороод дээр нэгтгэсэн санал хураалтын дүнг хуулбарлан өгөх, мэдээлэх, сонгуультай холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт тавих боломж нээлттэй байх ёстой.

- d) Улс төрийн нам, нэр дэвшигч, бүх нийтийн санал асуулга явуулж буй асуудлаар эсрэг болон дэмжсэн байр суурьтай байгаа талууд сонгуулийн эрх нь зөрчигдсөн талаар гаргасан гомдол, бусад гомдол маргааны тухай мэдээллийг цаг тухайд авах боломжтой байх ёстой.
- e) Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд үндэсний болон олон улсын бусад байгууллагуудтай нэгдэх, хамтран ажиллах тэднээс санхүүгийн болон бусад туслалцаа авах боломжтой байх ёстой.
- f) Сонгуулийн хяналт, ажиглалт хийж буй нам бус иргэний нийгмийн байгууллагууд нь интернет, хэвлэмэл болон цахим хэвлэл мэдээллээр, түүнчлэн аман харилцаа холбоогоор дамжуулж улс дотроо болон хилийн чанадаас мэдээлэл авах, хүсэх, дамжуулах эрхээ эдлэх боломжтой байх ёстой.
- g) Сонгуулийн ажиглалт, хяналт хийх нам бус иргэний нийгмийн байгууллагуудад санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх үндэсний болон олон улсын байгууллага, сангууд тухайн улс орны нөхцөл байдалд тохируулан сонгуулийн ажиглалт, хяналтын хамгийн системтэй аргачлалыг авч ажиллах, чадавхаа бэхжүүлэх боломжоор хангахыг эрмэлзэх ба үйл ажиллагаагаа явуулах цаг хугацаа, бусад нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой.
- h) Сонгуулийн асуудал эрхэлсэн байгууллага, төрийн бусад эрх бүхий байгууллагууд, түүнчлэн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн донорууд нь сонгуулийн ажиглалтын дүн мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж нь нам бус иргэний байгууллагуудын өөрсдийнх нь асуудал бөгөөд танилцуулах хугацаа, хэлбэрийг хуульд заасан шаардлагын дагуу иргэний нийгмийн байгууллагууд өөрсдөө тодорхойлох боломж өгөх ёстой.

Дээр дурдсан нөхцлүүд ямар түвшинд хангагдсан байгаа нь нам бус дотоодын байгууллагуудын хийх сонгуулийн ажиглалт, хяналтад нөлөөлнө. Ажиглагчдын аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүсэх, түүнчлэн сонгуулийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага нь сонгуулийг ажиглах, хянах магадлан итгэмжлэл олгохоос татгалзсан тохиолдолд дотоодын нам бус байгууллага сонгуульд системтэй хяналт тавих боломж хомс болно. Гэвч ийм хязгаарлалттай тулгарсан ч иргэний нийгмийн байгууллагууд ажиглагчдаа санал хураах байрны гадна эргүүл хийлгэж хэсэгчлэн дайчилж ажиллуулах, улмаар мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах боломжтой бөгөөд үүний нэг хэсэг болгон өөрсдөд нь учирсан бэрхшээлийн учир шалтгаан, болзошгүй үр дагаварыг судлан үзэх бололцоотой.

Хүлээх үүрэг, хариуцлага

- 19. Иргэдийн төрийн үйл хэрэгт оролцох эрхийг эрхэмлэн, бүх нийтийн хийгээд тэгш эрхэд суурилсан шударга ардчилсан сонгуулийг сахин хамгаалах зорилгын хүрээнд энэхүү тунхаглалд нэгдсэн байгууллагууд үйл ажиллагаандаа эмэгтэйчүүд, залуучууд, үндэсний цөөнх болон хүн амын бүх бүлгийг оролцоог хангахыг зорино.
- 20. Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа дотоодын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, пактаар хүлээсэн хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлагын хүрээнд сонгуульд оролцогч талууд хуулийн өмнө тэгш эрхтэйгээр ялгаварлан гадуурхалд өртөлгүйгээр сонгох, сонгогдох эрхээ эдэлж чадаж буй эсэхэд хяналт тавина. Энэхүү тунхагдалд нэгдэж байгаа

байгууллагууд нь эмэгтэйчүүд, залуучууд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, дотоодын дүрвэгсдийн сонгуульд оролцох оролцоо, төрийн эрх бүхий байгууллага, сонгуульд оролцож буй болон бусад талуудын зүгээс тэдний оролцоог дэмжихээр хийж буй алхмуудад үнэлгээ дүгнэлт өгч, сонгогчдын нэрийн жагсаалт, нэр дэвшүүлэх үйл явцад гарч байж болзошгүй бэрхшээл, үндэсний цөөнх өөрийн хэлээр мэдээлэл авч сонгуульд шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлэх асуудлаар зөвлөмж гарган дээр дурдсан бүлгүүдийн сонгуульд оролцох оролцоог аль болох дэмжинэ.

21. Энэхүү тунхаглалд нэгдсэн нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглаж, хянахдаа дараахь тодорхой үүрэг хүлээнэ:

- a) Байгууллагын удирдлага болоод сонгуулийг ажиглаж хянахад оролцож буй нам бус иргэд үйл ажиллагаандаа төвийг сахих, түүнчлэн ажиглалт хяналтаар бүрдүүлсэн мэдээлэл, дүн шинжилгээ нь нягт нямбай, үнэн зөв, цаг хугацаандаа багтаж гарах шаардлагыг дээд зэргээр ухамсарлана,
- b) Ажиглагчдаа сургаж, зохих ёсоор бэлдэх ба сургалтад дараахь гол асуудлыг хамруулна: (i) улстөрийн намаас тусдаа, бие даасан байх зарчим (энэхүү тунхаглалын гол утга), (ii) дотоодын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, үүрэг хариуцлага (шударга сонгуулийн талаар бүс нутаг хийгээд олон улсын өмнө хүлээсэн үүрэг), (iii) ажиглалт, хяналтын дүнг мэдээлэх протокол, дүрэм журам, (iv) нам сонгуулийг ажиглаж, хянах аргачлал, техник технологи,
- c) Байгууллагын удирдах зөвлөлийн гишүүд, удирдлага, ажилтнууд болон сайн дурын оролцогчид, сонгуулийн ажиглагч, хянагч, сургагч, зохион байгуулагч болон бусад оролцогч талууд энэхүү тунхаглалыг дагалдуулж буй Нам бус сонгуулийн ажиглагчийн баримтлах ёсзүйн дүрэм, эсвэл үүнтэй төстэй өөрсдийн байгууллагаас гаргасан ёсзүйн дүрмийг зөвшөөрч, дагаж мөрдөнө,
- d) Сонгуулийн асуудал эрхэлсэн байгууллага, төрийн бусад холбогдох байгууллага, газруудтай хамтран ажиллахыг чармайх бөгөөд шударга ардчилсан сонгуулийн хууль, дүрэм журмыг хүндэтгэн үзэж сонгуулийн байгууллагын ажилтан, нэр дэвшигчид болон сонгогчдод саад учруулахгүй ба сонгууль болон олон нийтийн санал хураалтын явцад сонгогчдын саналд нөлөөлөх улстөрийн намын шинж чанартай үйл ажиллагаа явуулахгүй.
- e) Төрөөс, тухайлбал сонгуулийн эрх бүхий байгууллагуудаас хараат бус байхын зэрэгцээ улстөрийн нам, нэр дэвшигч, тэрчлэн бүх нийтийн санал асуулга явуулж буй асуудлаар эсрэг болон дэмжсэн байр суурьтай талуудад төвийг сахисан байдлаар хандан үйл ажиллагаагаа ил тод явуулах бөгөөд чингэхдээ шударга, үнэн зөв, иргэдийн ашиг тусын төлөө цаг тухайд нь ажиглалт хийж мэдээлэл дамжуулахад саад болох, сонирхлын зөрчил үүсгэх аливаа эх сурвалжаас санхүүжилт авахгүй,
- f) Хянаж буй сонгуулийн үйл явц, улстөрийн намаас тусдаа, бие даасан байх зарчим болон дотоодын онцлог нөхцөл байдалд тохирох хамгийн системтэй, шилдэг аргачлал, техникийг ашиглана,
- g) Дүн шинжилгээ хийхдээ зөвхөн баримтад үндэслэн аль нэг талыг барихаас зайлсхийх ба дотоодын хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээр, бусад баримт бичгээр хүлээсэн тодорхой үүрэг хариуцлага, холбогдох олон улсын сайн туршлагыг харгалзан дүгнэлт, зөвлөмжөө боловсруулах ба үйл ажиллагаандаа баримтлал болгосон шалгуур үзүүлэлтийн талаар мэдээллээ нийтэд ил тод байлгана,
- h) Сонгуулийн үйл явцтай холбоотой үнэн зөв, төвч мэдээллийг цаг тухайд нь олон нийт болон бусад сонгуульд оролцогч талуудад хүргэх ба үүнд баримтад тулгуурласан шинжилгээ, ажиглалт, дүгнэлт, түүнчлэн хуулийн зохимжгүй заалт, үндэслэлгүй хязгаарлалт болон шударга ардчилсан сонгууль

явуулахад тулгарч буй бусад саад бэрхшээлийг арилгах, сонгуулийн үйл явцыг сайжруулах талаар зөвлөмж багтаана,

- i) Дотоодын нөхцөл байдлыг харгалзан энэхүү тунхаглалд нэгдсэн орсон, хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж буй бусад нам бус байгууллагуудтай аль болох хамтран ажиллана,
 - j) Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын сонгуулийн ажиглагчид, шударга ардчилсан сонгуулийг дэмжих чиглэлээр ажилладаг бусад талуудтай хамтран ажиллана,
 - k) Боломжтой нөхцөлд сонгуулийн эрхзүйн орчин, хэрэгжилтийг сайжруулах, сонгуулийн болон улс төрийн үйл ажиллагааг нээлттэй, хариуцлагатай, хүчирхийллээс ангид явуулах, сонгуулийн болон улс төрийн үйл ажиллагаанд иргэдийг бүрэн оролцуулахад саад болж буй үндэслэлгүй хязгаарлалт, бэрхшээлийг арилгахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ авч ардчилсан засаглалыг сайжруулахад өргөн цар хүрээнд хувь нэмрээ оруулахаар хичээнгүйлэн зүтгэнэ,
 - l) Энэхүү тунхаглал болон холбогдох ёсзүйн дүрмийг иргэд болон сонгуулийн бусад оролцогч талуудад хүргэх, мэдээлнэ.
22. Уг тунхаглалд нэгдэн орсон нам бус иргэний байгууллагууд нь энэхүү баримт бичгийг болон дагалдах нам бус сонгуулийн ажиглагчийн баримтлах ёсзүйн дүрмийн зүйл заалтууд, зорилгыг биелүүлэхэд бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллана. Энэхүү тунхаглалд нэгдсэн аливаа байгууллага сонгуулийн ажиглалт, хяналт хийхдээ үндэсний нөхцөл байдалд тохируулан тунхаглалын болон дагалдах ёсзүйн дүрмийн зарим зүйл заалтыг үл мөрдөх шаардлага тулгарвал энэ тухайгаа олон нийтэд мэдээлэх бөгөөд энэхүү шийдвэрийнхээ талаар тунхаглалд нэгдсэн орсон бусад байгууллагуудын тавих асуултанд хариулахад ямагт бэлэн байна.

Нэгдэх, элсэх

23. Энэхүү тунхаглалд болон Нам бус сонгуулийн ажиглагчийн баримтлах ёсзүйн дүрэм нь сонгуульд мониторинг, ажиглалт хийх чиглэлээр ажилладаг нам бус иргэний нийгмийн байгууллагууд хийгээд тэдгээрийн нэгдэн байгуулсан бүс нутгийн сүлжээ нэгдэн орох үүд хаалга нээлттэй байна. Дээрх бүх байгууллага болон сүлжээг “нэгдэж орсон байгууллага” гэгдэнэ.
24. Энэхүү тунхаглал болон холбогдох ёсзүйн дүрэмд иргэний нийгмийн байгууллагын сонгуульд тавих хяналтыг дэмждэг, тэдэнтэй хамтран ажилладаг засгийн газар хоорондын байгууллага, олон улсын төрийн бус байгууллага, бусад байгууллагууд элсэн орж болох бөгөөд тэдгээрийг “тунхаглалыг дэмжигчид” гэнэ.
25. Уг тунхаглалд нэгдэн орох, дэмжих байгууллагуудыг *Сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын олон улсын сүлжээ*, энэхүү тунхаглал, ёсзүйн дүрэмд нэгдэн орсон бүс нутгийн сүлжээд, түүнчлэн эдгээр баримт бичгийг боловсруулахад оролцогч талуудын дунд зөвшилцөл бий болгон гол үүрэг гүйцэтгэсэн Үндэсний Ардчилсан Институци тус тус бүртгэх ба энэ талаар бусад байгууллагуудад цаг тухайд нь мэдээлнэ.

НАМ БУС СОНГУУЛИЙН АЖИГЛАГЧ, ХЯНАГЧИЙН БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Танилцуулга

Улстөрийн намаас тусдаа бие даасан иргэний байгууллагуудын сонгуульд хийх ажиглалт, мониторинг нь сонгуулийн шударга байдлыг сахин хамгаалах, ардчилсан сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, сонгуулийн зөрчил, будлианаас сэргийлэхэд чухал нөлөөтэй гэж дэлхий даяар улам бүр хүлээн зөвшөөрөх болжээ. Янз бүрийн орны засгийн газар болоод сонгуулийн асуудал эрхэлсэн байгууллагууд, нэр дэвшигчид хийгээд бусад оролцогч талуудын зүгээс ийм бие даасан сонгуулийн ажиглалт, хяналт нь иргэдийн төрийн үйл хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлэх нэг арга хэлбэр мөн болохыг басхүү хүлээн зөвшөөрч байна. Засгийн газар хоорондын байгууллагууд болон олон улсын хэд хэдэн гэрээ, тунхаглал, эрхийн актуудад нам бус иргэний нийгмийн байгууллагуудын сонгуульд хийх ажиглалт, хяналт нь жинхэнэ ардчилсан сонгуулийг дэмжин урагшлуулах чухал хүчин зүйл мөн болохыг цохон тэмдэглэсэн билээ.

Нам бус иргэний нийгмийн байгууллагын сонгуульд тавих хяналт, ажиглалтын гол зорилго нь сонгуулийг нь нээлттэй, ил тод, Үндсэн хууль, бусад холбогдох хууль, дүрэм журам, олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, хариуцлагын хүрээнд зохион байгуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч сонгуулийн үйл явцыг бүхэлд нь үнэн зөв, төвийг сахьсан байр суурьнаас гэрчлэн мэдээлэх замаар сонгууль шударга явагдахад тус дөхөм үзүүлэх явдал юм. Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд оролцож буй бүх оролцогчдыг (нэр дэвшигчид, улстөрийн намууд, бүх нийтийн санал асуулга явуулах санаачлагыг дэмжигчид эсвэл эсэргүүцэгчид, сонгуулийг удирдан зохион байгуулж буй албан тушаалтнууд, бусад төрийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл болон сонгогчид) хуулиа биелүүлж иргэдийн сонгуулийн эрхэд хүндэтгэлтэй хандахыг шаардан хууль, иргэдийн эрхийг зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох нөхцлийг бүрдүүлнэ. Түүнчлэн төрийн үйл хэргийг удирдахад оролцох өөрсдийнхөө эрхийг сонгуулийн ажиглагчийн хувиар хэрэгжүүлэхэд иргэдийг урайлан дайчилж сонгуулийн болон улс төрийн үйл явцад иргэдийн оролцоог илүү өргөн хүрээтэй болгодог.

Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд ажиглалт хийх, хяналт тавих эрхийг өндөр хариуцлага дагалдана. Иймд сонгуульд ажиглалт, хяналт хийж буй бүх байгууллага улстөрийн хувьд төвийг сахих гэх мэт хүлээвэл зохих тодорхой хариуцлагын талаар ёс зүйн дүрэмдээ заах бололцоотой. Ажиглагч, хянагчдийн эрх, үүрэг хариуцлагыг ёс зүйн дүрмээс өөр хэлбэрээр тухайн байгууллагын үйл ажиллагааны зарчим байдлаар мөн баталж болно.

Нам бус иргэний нийгмийн байгууллагуудын сонгуульд бие даасан ажиглалт, хяналт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглалыг хүлээн зөвшөөрч буй байгууллагууд, сүлжээд нь тухайн байгууллага эсвэл сүлжээний өөрийн гэсэн ёс зүйн дүрэм болон үйл ажиллагааны зарчмаас гадна энэхүү Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч дагаж мөрдөнө. Үүнд байгууллагын удирдлага, ажилтнууд, зөвлөхүүд, түүчлэн хянагч, ажиглагчид энэхүү Ёс зүйн дүрмийг эсвэл үүнтэй утга санаа ижил тухайн байгууллага, сүлжээний ёс зүйн дүрмийг баримтлах ба доор танилцуулж буйтай утга агуулгын хувьд зөрүүгүй амлалтанд гарын үсэг зурж дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

Ёс зүйн дүрэм

Сонгуульд хараат бус, бие даасан ажиглалт хяналт хийх зорилго, зорилтод хүрэхийн тулд байгууллага, сүлжээ бүр дараах зарчмаар ажиллахаар зөвшөөрч байна. Үүнд:

- 1) Сонгуулийн үйл явцтай холбоотой хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаандаа (ажиглалт, хяналт хийх, сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх, санал өгсөн

сонгогчдоос судалгаа авах) улстөрийн хувьд төвийг сахих байр суурь баримтлах ба төрийн эрх мэдэлд хүрэхийг эрмэлзэгч аливаа нэр дэвшигч, улстөрийн нам, бүлэг, хөдөлгөөн, холбоо, түүнчлэн бүх нийтийн санал асуулга явуулах санаачлагын талаар эсрэг тэсрэг байр суурьтай байгаа талуудыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн (нам, нэр дэвшигчид эсвэл бүх нийтийн санал асуулгаар янз бүрийн байр суурьтай талууд хууль зөрчсөн, сонгуулийн эрхэд халдсан тухай баримтад тулгуурлан мэдэгдэхэд үүнийг мөн анхаарна) байр суурь олон нийтэд илэрхийлэхээс түдгэлзэх, улстөрийн өрсөлдөгчид эсвэл тэднийг төлөөлсөн байгууллагаас санал болгосон бүхий л тусламж, шан харамж эсвэл сүрдүүлгийг хэрэгсэж хүлээн авалгүйгээр улс төрөөс хараат бус байх байр суурийг хатуу баримтлах;

- 2) Сонгуулийн үр дүнд хэн ялж ялагдахаас үл хамааран жинхэнэ ардчилсан сонгуулийн үйл явцыг дэмжин төрөөс хараат бус, бие даасан байдлаар ажиллах ба сонгуулийн үйл явцыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг үр дүнтэй ажиглан хянахын зэрэгцээ холбогдох улстөрийн орчинд ул суурьтай дүн шинжилгээ хийхийн тулд тухайн улсын нөхцөл байдалд тохирсон, улстөрийн хувьд төвийг сахих зарчимд нийцэх шалгарсан аргачлал, техникийг ашиглах;
- 3) Хүчирхийллээс зайлсхийх зарчмыг чанд баримталж сонгуулийн үйл явцад оролцогч бүх талуудыг мөн тийм зарчим баримтлахыг уриалж сонгуультай холбоотойгоор гарч болох хүчирхийллээс сэргийлэх боломжтой бүхий л арга хэмжээ авах;
- 4) Ардчилсан сонгууль явуулахтай холбоотой өөрийн улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээ, пактын зүйл заалтыг хүндэтгэн үзэж сонгуультай холбоотой эрхүүдэд хүндэтгэлтэй хандан зөрчихгүй байхыг сонгуульд оролцогч бусад талуудад хандан уриалах;
- 5) Шударга сонгууль зохион байгуулах үүрэг хүлээсэн төрийн холбогдох бүх түвшний байгууллагын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, тэдний үйл ажиллагаанд зохисгүй, хууль зөрчсөн байдлаар нөлөөлж саад учруулахгүй байх, бие даасан, хараат бус сонгуулийн хороодтой хамтран ажиллахыг хичээх бөгөөд сонгуулийг шударга явуулах, хамгаалахтай холбоотой өгсөн хууль ёсны зааварчилгаа удирдамжийг дагаж мөрдөх;
- 6) Бүх иргэд чөлөөтэй, аливаа ялгаварлан гадуурхалд, сүрдүүлгэд өртөлгүй сонгуульд оролцож эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх, үүнд саналын нууцлалыг сахин хамгаалах, түүнчлэн эмэгтэйчүүд, залуучууд, уугуул иргэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад эмзэг бүлгийн иргэд сонгогчдын нэрийн жагсаалтад саадгүй бүртгүүлэх, мэдээлэлтэйгээр сонголт хийж саналаа гаргахын тулд өөрсдийн ойлгох хэл дээр үнэн зөв мэдээлэл авах, сонгуулийн үйл явцад бусад байдлаар оролцоход нь туслах;
- 7) Улстөрийн хувьд төвийг сахих байр сууриа алдахгүйгээр сонгуульд өрсөлдөгч талууд сонгогдох эрхээ аливаа ялгаварлал гадуурхал, зүй бус хязгаарлалтад өртөлгүй эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх, үүнд хуулийн дагуу бүртгүүлэх, сонгуульд оролцоход нь зүй бус шаардлага тавьж буюу бусад аргаар саад учруулахгүй байх, сонгогчдын дэмжлэгийг татах зорилгоор кампанит ажлаа чөлөөтэй явуулах, улстөрийн байр суурь, бодлогоо олон нийтэд хүргэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхээ саадгүй эдлэх, сонгуулийн үйл явцыг бүхэлд нь хянах, сонгуультай холбоотой гомдлоо зохих ёсоор шийдвэрлүүлэх боломжоор хангагдах болон хувь хүний халдашгүй эрхээ эдлэхэд нь туслах;
- 8) Нам бус иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс сонгуульд бие даасан ажиглалт, хяналт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн бусад иргэний байгууллагууд, тэдний томилсон ажиглагчидтай хамтран ажиллах, сонгуулийн ажиглалт хийж буй олон улсын ажиглагчидтай хамтран ажиллахыг чармайх;

- 9) Ажиглалтын дүнг цаг тухайд нь үнэн зөвөөр, төвийг сахьсан байр суурьнаас мэдээлэх, ингэхдээ ажиглалт, мониторингоор илэрсэн эерэг, сөрөг бүхий л баримтыг мэдээлэлдээ багтаан болсон үйл явдлыг нягтлан шалгах боломж олгохын тулд бүх ноцтой асуудлуудыг хангалттай баримтжуулах ба сонгуулийн үйл явцын талаар бодитой ойлголт өгөх үүднээс эерэг үйл явцыг мөн хангалттай баримтжуулж мэдээлэх,
- 10) Бүх ажиглагчид, хянагчдад энэхүү Ёс зүйн дүрмийг нухацтай ойлгох бололцоо олгох үүднээс өндөр чанартай сургалтыг зохион байгуулах, доор дагалдах амлалтыг бүх утгийг нь нарийн ойлгон дэмжиж гарын үзэг зурах боломж олгох, энэхүү Ёс зүйн дүрмийн стандартыг хангасан тайлан гаргах.

Ёс зүйн талаарх дээр дурдсан 10 зүйлийг тухайн улсын нөхцөл байдалд тохируулан өөрчилж эсвэл нэмж баяжуулж болно. Сонгуулийн ажиглагчид нь энэхүү дүрмийг уншиж танилцсан байх шаардлагатай бөгөөд уг Ёс зүйн дүрмийн зүйл заалтад утга агуулга, үзэл санааны хувьд нийцсэн улстөрөөс ангид хараат бус, бие даасан зарчмаар ажиллах амлалтанд гарын үсэг зурж зөвшөөрнө.

Энэхүү Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд ажиглагчийг томилсон иргэний нийгмийн байгууллага нь тухайн зөрчлийг нягтлан шалгана. Хэрэв ажиглагч ноцтой зөрчил гаргасан болохыг олж тогтоовол мониторинг, ажиглалтын үйл ажиллагаанд цаашид оролцуулахаас татгалзах, магадлан итгэмжлэлийг түтгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна. Энэ асуудлаар шийдвэр гаргах эрхийг зөвхөн тухайн байгууллагын удирдлага эдлэнэ.

Сонгуульд улстөрөөс ангид хараат бус, бие даасан хяналт, ажиглалт хийх амлалт (жишээ)

Хаалтанд байгаа хэсгийг өөрийн улсын нөхцөлд тохиромжтой үг хэллэгээр солих бололцоотой.

Сонгуулийн ажиглагчийн амлалт (тангараг)

Энэхүү баримт бичигт гарын үсэг зурж зөвшөөрснөөр миний бие дараах үүрэг амлалт авч байна. Үүнд:

- 1) Би сонгуулийн үеэр сонгуулийн ажиглагчаар ажиллаж сонгогчдын нэрийн жагсаалт, нэр дэвшигчийг бүртгэх үйл явц, улстөрийн нам нэр дэвших хүмүүсээ сонгох үйл явц, сонгуулийн кампанит ажил, сонгуулийн үеэрх хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, санал хураах, тоолох, дүнг нэгтгэх үйл явцад мониторинг, ажиглалт хийхдээ сонгогчийн санал, шийдвэрт нөлөөлөх зорилготой аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд сонгууль/бүх нийтийн санал асуулга зохион байгуулах үүрэг хүлээсэн төрийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж хөндлөнгөөс зохисгүй байдлаар нөлөөлж саад учруулахгүй.
- 2) Би сонгуульд нэр дэвшигч биш бөгөөд аливаа нэр дэвшигч, улстөрийн нам, бүлэг, хөдөлгөөн, бусад холбооны төлөө ажилладаг идэвхтэн биш, мөн бүх нийтийн санал асуулгыг дэмжигч юмуу эсэргүүцэгч биш болно. Би энэ сонгуульд нэр дэвшихгүй бөгөөд дараа дараагийн сонгуульд өөрийн нэрийг дэвшүүлэхэд сонгуульд улстөрийн намаас хараат бус, бие даасан мониторинг, ажиглалт хийж иргэний байгууллагыг ашиглах гээгүй болно.
- 3) Би улстөрийн хувьд төвийг сахих байр суурин дээр хатуу зогсож сонгуулийн үйл явцтай хамааралтай бүхий л үйл ажиллагаанд оролцохдоо аль нэг талыг барихгүй ба төрийн эрх мэдэл олж авахаар эрмэлзэгч аливаа нэр дэвшигч, улстөрийн нам, бүлэг, хөдөлгөөн, холбоо эсвэл аливаа бүх нийтийн санал асуулга

явуулах санаачлагыг дэмжигчид эсвэл эсэргүүцэгчдийн төлөө эсвэл эсрэг аливаа тайлбар олон нийтэд гаргахаас түдгэлзэнэ. Түүнчлэн, сонгуульд өрсөлдөгч талууд эсвэл тэднийг төлөөлөн санал болгосон бүхий л тусламж шан харамж эсвэл гаргасан сүрдүүлгийг хэрэгсэж хүлээн авалгүйгээр төвийг сахьсан байр суурийг хатуу баримтлах болно.

- 4) Би санал хураах бүхээгт нууцаар саналаа өгөх эрхээ хэрэгжүүлэхээс бусад үед ардчилсан үйл явцийг дэмжих үүднээс сонгуульд хэн ялах, ялагдахаас үл хамааран жинхэнэ ардчилсан сонгуулийн үйл явцийг дэмжиж төрийн эрх мэдэл олж авахаар эрмэлзэж буй нэр дэвшигчид эсвэл бүх нийтийн санал асуулгаар хэлэлцэгдэх асуудлуудын талаарх өөрийн хувийн бодлыг хойш тавин ажиллах болно.
- 5) Надад ашиг сонирхолын зөрчил байхгүй бөгөөд сонгуульд улстөрийн намаас хараат бус, бие даасан ажиглалт хяналт хийх үйл ажиллагааг шударгаар, үнэн зөвөөр цаг хугацаанд нь гүйцэтгэн явуулахад саад учруулах аливаа хувийн, улс төрийн, эдийн засгийн эсвэл бусад ашиг сонирхлын зөрчил гаргахгүй.
- 6) Би сонгуульд бие даасан хяналт тавьж буй байгууллагын нэр хүндэд харшлар аливаа үйлдэл гаргахыг цээрлэн энэхүү Ёс зүйн дүрмийг чанд баримтлах ба мониторинг, ажиглалт хийж буй иргэний нийгмийн байгууллагаас бичгээр өгсөн аливаа удирдамж (ажиглалт хяналтын протоколууд, удирдамж зэрэг) болон аман зааварчилгааг хүндэтгэн үзэж дагах болно.
- 7) Байгууллагын удирдлагаас өөрөөр тусгайлан удирдамж өгснөөс бусад тохиолдолд би сонгуулийн ажиглалт, мониторингийн дүнгийн талаар байгууллага албан ёсны мэдэгдэл хийхээс өмнө өөрийн хувийн аливаа санаа бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсвэл олон нийтэд мэдээллэхээс татгалзана.
- 8) Би сонгуулийн ажиглалт, мониторингийн бүх сургалтад оролцох ба сонгуулийн хууль тогтоомж болон бусад холбогдох дүрэм журамтай танилцаж хангалттай ойлголттой болно. Би байгууллагаас боловсруулсан аргачлалын дагуу мэдээлэл цуглуулж ажиллах ба сонгуулийн мониторинг, ажиглалт хийх үйл явцад өөрийн бүхий л чадварыг дайчлан ажиллах болно.
- 9) Би сонгуулийн ажиглагч эсвэл хянагчийн хувиар ажигласан бүх үйл явцыг шударгаар, үнэн зөвөөр цаг хугацаанд нь (эерэг ба сөрөг хүчин зүйлсийг оролцуулан) тайлагнаж мэдээлнэ.
- 10) Би сонгуулийн нам бус ажиглагч / хянагчийн Ёс зүйн дүрмийг анхааралтай уншиж бүрэн ойлгосон бөгөөд түүний зорилго зарчмуудыг дэмжин, тусгагдсан шаардлагуудад нийцүүлэн ажиллахыг зөвшөөрч байгаагаа үүгээр зөвшөөрч байна. Хэрэв сонгуульд улстөрөөс хараат бус, бие даасан ажиглалт хяналт хийх ажлыг шударгаар, үнэн зөвөөр, цаг хугацаанд нь гүйцэтгэн явуулахад саада учруулахуйц аливаа хувийн, улстөрийн, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын зөрчил үүсвэл эсвэл энэхүү Ёс зүйн дүрмийн шаардлагыг зөрчсөн бол сонгуулийн ажиглагч эсвэл хянагчийн үүргээсээ татгалзахаа би үүгээр мөн тангараглаж байна.

..... Гарын үсэг.....Огноо

..... Нэр (дармал үсгээр)

Талархал

Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд хяналт тавих, ажиглалт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглал болон Иргэний байгууллагуудын томилсон нам бус сонгуулийн ажиглагчийн ёс зүйн дүрмийг нь *Сонгуульд хяналт тавьдаг иргэний нийгмийн байгууллагуудын олон улсын сүлжээ (СХИНБОУС)*-нээс санаачилсан бөгөөд Үндэсний ардчиллын хүрээлэнгээс (NDI)¹ өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлж дэмжлэг үзүүлсний үр дүнд бий болсон юм. Хэлэлцүүлэгт сонгуулийн чиглэлээр ажилладаг дотоодын нам бус байгууллагуудын бүсийн сүлжээд болон сүлжээ хараахан байгуулагдаагүй газруудад сүлжээ байгуулахаар гаргасан санаачлагуудын төлөөлөгчид багтсан болно.

Төлөөлөгчид нь Тунхаглалын төсөл боловсруулах баг байгуулсан бөгөөд холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрүүд, бүс нутгийн тунхаглалууд болон бусад баримт бичгүүд, *2005 оны Сонгуулийн олон улсын ажиглалтын зарчмын тунхаглал* болон түүнийг дагалдах Ёс зүйн дүрэм зэрэг бичиг баримттай танилцан судалж бэлтгэл ажлыг хангасан. Уг Тунхаглалын төсөл боловсруулах бүлэг 2010 оны 5 сарын 24-25 өдрүүдэд Өмнөд Африкын Ёоханесбург хотноо хуралдан 2010 оны 5 сарын 25-ны өдөр Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд хяналт тавих, ажиглалт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглал болон Иргэний байгууллагуудын томилсон нам бус сонгуулийн ажиглагчийн ёс зүйн дүрмийн төслийг гаргасан билээ. Уг хуралдааныг Өмнөд Африкын хөгжлийн хамтын нийгэмлэгийн сонгуулийг дэмжих сүлжээ (ӨАХХНСДС) хамтран зохион байгуулсан юм.

Дээрх хурлаас гаргасан Тунхаглалын төслийг *СХИНБОУС* -ний бүх 125 гишүүнд санал авахаар тараан өгсөн. Энэхүү санаачилгад оролцсон бүс нутгийн сүлжээд мөн уг төслийг өөрсдийн гишүүдэд тараасан ба бүс нутгийн сүлжээнд элсээгүй байгууллагуудад хүргэх, тэднээс санал авах ажлыг *СХИНБОУС* зохион байгуулсан юм. Холбогдох сүлжээд нь гишүүдийнхээ саналыг цуглуулан Тунхаглалын төсөл боловсруулах багт хүлээлгэн өгсөн ба багийн зүгээс бүх саналыг нягтлан үзээд нэгтгэж зохих өөрчлөлтийг Тунхаглалын төсөлд тусгасан. Энэхүү өөрчлөлт оруулсан төслийг мөн сүлжээний төлөөлөгчид авч үзээд эцсийн байдлаар санал нэгдэж гаргасан юм.

2010 оны 7 дугаар сараас эхлэн Нам бус иргэний нийгмийн байгууллагууд сонгуульд хяналт тавих, ажиглалт хийхэд баримтлах түгээмэл зарчмын тунхаглал болон Иргэний байгууллагуудын томилсон нам бус сонгуулийн ажиглагчийн ёс зүйн дүрмийг зөвшөөрөн нэгдэн орох хүсэлтэй *СХИНБОУС* -ний гишүүдэд түгээх ажлыг зохион байгууллаа.

Тунхаглалын төсөл боловсруулах бүлэгт багтсан гишүүд:

Африкын сүлжээд болон сүлжээний санаачлагууд

Малавигийн сонгуулийг дэмжих сүлжээний (МСДС) Стив Дува болон Алойсиоус Нтенда нар ӨАХХНСДС-г төлөөлсөн. МСДС-ийн төлөөлөгч нь Өмнөд Африкын хөгжлийн хамтын нийгэмлэгт (ӨАХХН) багтсан 14 улсын нам бус иргэний байгууллагуудаас бүрдсэн ӨАХХНСДС-г одоогоор даргалж байгаа юм.

¹ Хэрэв энэхүү баримт бичигт НҮБ “Тунхаглалыг дэмжигч” байдлаар оролцохыг НҮБ-ын Хуулийн хэрэг эрхлэх газар зөвшөөрвөл, НҮБ-ын Сонгуульд туслах газар ҮАХ-ийн хамтаар энэхүү Тунхаглал болон Ёс зүйн дүрмийг боловсруулах үйл явцийг дэмжигчид гэж зөвшөөрөгдөх болно.

ӨАХХНСДС-ний нарийн бичгийн дарга нарийн газрыг ажиллуулдаг Зимбабвегийн сонгуулийг дэмжих сүлжээний (ЗСДС) Барбара Нянгари болон Риндай Чипфунде нар мөн ӨАХХНСДС -г төлөөлөн оролцсон.

Гана улсад сонгуулийн нам бус ажиглалт хяналтыг явуулдаг бөгөөд Баруун Африкын сонгуулын нам бус ажиглалт хяналтын байгууллагуудын сүлжээг боловсруулахад оролцсон Арчилсан хөгжил / дотоодын сонгуулийн ажиглагчдын коалицийн Ганийн төвийг Кожо Асанте төлөөлсөн.

Питер Алинго Окот нь Кени улсад сонгуулийн нам бус ажиглалт хяналтыг явуулдаг бөгөөд Хорн ба Зүүн Африкын сонгуулын нам бус ажиглалт хяналтын байгууллагуудын сүлжээний хөгжлийг дэмжихэд оролцсон Ардчилал дахь боловсролын хүрээлэнгийн гүйцэтгэх захирал юм.

Ази

Тайланд болон Филиппинээс ирсэн Санжай Гатиа болон Дамасо Г. Магбуал нар Ази даяарх сонгуулын нам бус ажиглалт хяналтын 21 байгууллагуудаас бүрдсэн Азийн Чөлөөт сонгуулийн төлөө сүлжээг (АЧСС) төлөөлсөн.

Европ ба Еврази

Сонгуулын хяналтын байгууллагуудын Европын сүлжээний (СХБЕС) ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд Макадониагийн Иргэдийн ассоциацийн гүйцэтгэх захирал Дарко Алексов нь Европ ба Евразийн сонгуулын нам бус ажиглалт хяналтын 22 байгууллагуудаас бүрдсэн СХБЕС-г төлөөлсөн.

Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд

Латин Америкын ба Карибын тэнгисийн орнуудын сонгуулын нам бус ажиглалт хяналтын 18 байгууллагуудаас бүрдсэн Акуердо де Лима сүлжээг Перугийн сонгуулын нам бус ажиглалт хяналтын байгууллага болох Трансаренсиа байгууллагын Эмми Деккер болон Перси Медина нар төлөөлөн оролцов.

Ойрхи дорнод

Левани улсад сонгуулийн нам бус ажиглалт хяналтыг явуулдаг бөгөөд Ойрхи Дорнод болон Хойд Африкын сонгуулын нам бус ажиглалт хяналтын байгууллагуудын сүлжээний хөгжлийг дэмжихэд оролцсон Ардчилсан сонгуулийн Леваний ассоциацийг Набил Хассан төлөөлөв.

Дэмжигчид²

ҮАХ дэх Сонгуулийн хөтөлбөрийн захирал Патрик Мерлоэ

ҮАХ дэх Сонгуулийн хөтөлбөрийн ахлах зөвлөх Ричард Клэйн

СХБЕС-ий ерөнхий нарийн бичгийн дарга байсан бөгөөд Словакт сонгуулын нам бус хяналт явуулдаг Сивик Ай байгууллагын өнөөгийн гүйцэтгэх захирал Питер Новотни уг Тунхаглалын төсөл боловсруулах бүлгийн Ёоханесбургийн хуралдаан дээр бичгээр саналаа өгсөн бөгөөд хэдэн арван ДСХГС-ий гишүүн байгууллагуудаас Тунхаглалын төсөлд оруулах саналууд хүлээн авсан болно.

² Хэрэв энэхүү баримт бичигт НҮБ “Тунхаглалыг дэмжигч” байдлаар оролцохыг НҮБ-ын Хуулийн хэрэг эрхлэх газар зөвшөөрвөл, НҮБ-ын Сонгуульд туслах газрын Андрю Брюс энэхүү Тунхаглал болон Ёс зүйн дүрмийг боловсруулах үйл явцийг дэмжигч гэж зөвшөөрөгдөх болно.

Хавсралт

Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийг ажиглах, хянахтай холбоотой олон улсын тунхаглал, баримт бичгийн жагсаалт

Олон улсын хүний эрхийн болон бусад баримт бичгүүд

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)
- Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (1966)
- Арьс өнгөөр ялгаварлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1965)
- Эмэгтэйчүүдийг ялгаварлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979)
- Авилгалын эсрэг конвенц (2003)
- Хөдөлмөрийн чадваргүй хүний эрхийн тухай конвенц (2006)
- Суурь эрх чөлөө болон түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг хамгаалах нийгмийн байгууллага, бүлэг хувь хүмүүсийн эрх, хариуцлагын талаарх тунхаглал (“Хүний эрх хамгаалагчдын тухай тунхаглал” НҮБ Дос: a/res/53/144: 1999 оны 3 сарын 8)
- Ерөнхий санал 25: Төрийн үйл хэрэгт оролцох эрх, сонгох эрх, төрийн үйлчилгээг вавах тэгш эрх (Зүйл 25), НҮБ-ын Хүний эрхийн хороо: Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын гэрээ хэлэлцээр (1966.7.6.12)
- Эмэгтэйчүүдийг ялгаварлах явдлыг устгах НҮБ-ын хороо, Улс төр нийгмийн амьдралын талаарх ерөнхий зөвлөмж 23 (1997)
- Дотоод шилжин суурьшилтанд баримлах зарчим (НҮБ-ын баримт бичиг E/CN.4/1998/53/Add.2)
- Парламент хоорондын холбооны чөлөөт шударга сонгуулийн шалгуурын тухай тунхаглал (1994)
- Сонгуулын олон улсын ажиглалтын зарчмуудын тунхаглал болон Сонгуулийн олон улсын ажиглалт хийх ёс зүйн дүрэм (2005 оны 10 сарын 27)

Африк-Африкын Холбоо, ECOWAS буюу БАОЭЗХН болон ӨАХБ зэрэг байгууллагуудыг оролцуулан

Африкын Холбоо

- Хүн ба ард түмний эрхийн талаарх Африкын хэлэлцээр (1981)
- Африк дахь эмэгтэйчүүдийн эрхийн талаар Хүн ба ард түмний эрхийн талаарх Африкын хэлэлцээрт оруулсан протокол (2003)
- Ардчилал, сонгууль болон засаглалын талаарх Африкын хэлэлцээр (2007, одоо хүртэл хүчин төгөлдөр болоогүй байгаа)
- Авилгалтай тэмцэх урьдчилан сэргийлэх Африкын Холбооны конвенц (2003)
- Африкт дотооддоо шилжин суурьшсан хүмүүсийг хамгаалах, туслалцаа үзүүлэх тухай конвенц (2009 оны Кампалагийн конвенц, өнөөг хүртэл хүчин төгөлдөр болоогүй байгаа)
- Африкын Холбооны “Африкт ардчилсан сонгуулийг удирдах зарчмын талаарх тунхаглал” (2002)
- Африкыг хөгжүүлэх шинэ түншлэлийн “Ардчилал, улс төр, эдийн засаг болон компаний засаглалын тухай тунхаглал” (2002)

Баруун Африкын орнуудын эдийн засгийн хамтын нийгэмлэг (БАОЭЗХН)

- БАОЭЗХН-ийн Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, менежмент, шийдвэрлэлт, энх тайвныг хамгаалах болон аюулгүй байдлын механизмтай холбоотой протоколд нэмэлт байдлаар оруулсан Ардчилал ба сайн засаглалын тухай протокол (2001)

Өмнөд Африкын хөгжлийн хамтын нийгэмлэг

- ӨАХХН-ийн Ардчилсан сонгуулийг удирдах зарчим, чиглэл (2004)
- ӨАХХН-ийн Парламентын форумаас баталсан ӨАХХН-ийн бүс нутаг дахь сонгуулийн норм стандартууд (2001)
- ӨАХХН-ийн бүс нутаг дахь сонгуулийн менежмент, хяналт ажиглалтын зарчмууд (2003 оны 11 сарын 6, Ёрханесбург, Өмнөд Африк, Өмнөд Африкын сонгуулийн комиссын форум болон сонгуулийн байгууллага)

Америк тив

- Хүний эрхийн тухай Америкын конвенц (1969)
- Хүний эрх үүргийн талаарх Америкын тунхаглал (1948)
- Эмэгтэйчүүдэд улс төрийн эрх олгох тухай Америк тивийн орнуудын конвенц (1948)
- Авилгалын эсрэг Америк тивийн орнуудын конвенц (1996)
- Америк тивийн орнуудын хоорондын Ардчилалын чартер (2001)

Ази

- Зүүн өмнөд Азийн орнуудын чартер (ASEAN 2007)
- ASEAN засгийн газар хоорондын хүний эрхийн комиссын (AICHR) хийх ажлын цах хүрээ (2009 оны 10 сарын 23- AICHR байгуулсан тухай Ча-ам Химийн тунхаглал)
- ANFREL-аас боловсруулсан ASEAN-ы орнуудын ардчилсан чөлөөт шударга сонгуулийн талаарх төсөөлөл (2009 оны 2 сарын 26, Ча-ам, Тайланд)

Европ – Европын зөвлөл, Европын холбоо, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага болон Тусгаар тогтносон орнуудын хамтын нөхөрлөл зэргийг оролцуулан

Европыг зөвлөл

- Хүний эрх суурь эрх чөлөөг хамгаалах Европын конвенц (1950, 2010 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон 14-р Протоколоос нэмэлт өөрчлөлт оруулсан)
- Хүний эрх суурь эрх чөлөөг хамгаалах Европын конвенцийн анхны протокол (1952)
- Үндэсний цөөнхийг хамгаалах Европын конвенц (1995)
- Орон нутгийн өөртөө засах засаглалын тухай Еуропын чартер (1985)
- Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Веницийн комисс) Сонгуулийн асуудлаар сайн практикын талаарх дүрэм (2002)

Европын холбоо

- Европын холбооны суурь эрхийн тухай чартер (2000)
- Европын холбоо, Африкын, Карибын болон Номхон далайн улсуудын хоорондох Котоноугийн гэрээ (2000)

Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага

- ЕАБХАБ-ын Хүний аспектын талаарх Копенгагены бага хурлын баримт бичгүүд (1990 оны 6 сарын 29, Копенгаген, Дани)
- ЕАБХАБ-ын Шинэ Европын төлөө Парисын чартер (1990)

Тусгаар тогносон орнуудын хамтын нөхөрлөл

- Хүний эрх суурь эрх чөлөөний талаарх ТТОХН-ийн конвенц (1995)
- ТТОХН-ийн гишүүн орнуудын Ардчилсан сонгууль, тэгш эрх болон эрх чөлөөний талаарх конвенц (2002)

Английн хамтын нөхөрлөл

- Хамтын нөхөрлөлийн зарчмуудын тунхаглал (1971)
- Харарын хамтын нөхөрлөлийн тунхаглал (1991)
- Харарын тунхаглалын талаарх хамтын нөхөрлөлийн Милбруккийн хөтөлбөр (1995)

Арабын орнуудын лиг болон Исламын конференц

- Хүний эрхийн Арабын чартер, Арабын орнуудын лиг (2004)
- Ислам дахь хүний эрхийн Кайрын тунхаглал, Исламын конференц (1990)

Бусад холбогдох баримт бичгүүд

- Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын бүсийн дотоодын сонгуулийн ажиглалтанд хандах нийтлэг хандлагын талаарх Загребын гэрээ (2003 оны 6 сарын 29, Загреб, Хорват)
- Европын дотоодын ажиглагчийн форумын тунхаглал (2003 оны 6 сарын 29, Загреб, Хорват)
- Дотоодын сонгуулийн ажиглалтын зарчмуудын талаарх тунхаглалын төсөл (2009 оны 1 сарын 29, Пакистаны Чөлөөт шударга сонгуулийн сүлжээ)